



2020 он 03 сар 30 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

**Цагаан Алт хөтөлбөрийн эргэлтийн хөрөнгийн
зээлийн гэрээ байгуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтыг тус тус удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Говь” ХК нь “Голомт Банк”-тай “Цагаан Алт хөтөлбөрийн эргэлтийн хөрөнгийн зээл”-ийн гэрээг дараах нөхцөлийн дагуу байгуулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 1.1. Зээлийн хэмжээ: 20,000,000,000 (хорин тэрбум) төгрөг;
 - 1.2. Зээлийн хугацаа: 24 (хорин дөрвөн) сар;
 - 1.3. Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа: 6 (зургаан) сар;
 - 1.4. Төгрөгийн зээлийн хүү жилийн: 16.0 (арван зургаан) хувь, Засгийн газраас хариуцан төлөх зээлийн хүүгийн хөнгөлөлт нь жилийн 10.0 (арван) хувь;
 - 1.5. Уг зээлийн эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг “Таван Богд Холдингс” ХХК батлан даах.
2. “Говь” ХК-ийн хөнгөлөлттэй зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Хавсралт №1-д заасан “Говь” ХК-ийн хөрөнгүүдийг нэмэлтээр барьцаалахыг зөвшөөрсүгэй.
3. Дээрх Зээлийн багц бүтээгдэхүүний нэмэлт гэрээ, барьцааны гэрээ, батлан даалтын гэрээ болон бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал (Б.Оргил)-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



Ц.БААТАРСАЙХАН

Б.АМАРСАЙХАН

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Б.ОРГИЛ

Ц.ОРГИЛБОЛД

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ